

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр дүгээр зүйлийн 2-т "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" заасны дагуу төрийн үйл ажиллагааны дээрх зарчмуудад нийцүүлэн явагдаг ёстой. Энэхүү зарчмын хүрээнд хууль дээдлэх зарчим нь төрийн албаны суурь зарчим юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй". Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3-т "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно" гэж заасан байна.

Төрийн албаны тухай 7 дугаар зүйлийн 7.1.2-т "Мэргэшсэн, тогтвортой байх", 7.1.3-т "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх" зарчмуудыг төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөхдөө баримтлах ёстой.

Үүний дагуу ерөнхий боловсролын сургуулийн захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт, томилогдох чөлөөлөгдөх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дээдлэх зарчим, Төрийн албаны тухай хуульд заасан зарчимтай уялдан холбогдох хуулиар зохицуулагдах ёстой.

Төрөөс олгож буй Боловсролын үйлчилгээг олгохдоо ямар нэгэн нийгэм, улс төр, хувийн ашиг сонирхолгүй явуулах нь нэн тэргүүний асуудал юм. Гэтэл сум, дүүргийн засаг дарга нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуульд заасны дагуу 4 жилийн хугацаатай томилогддог улс төрийн албан тушаалтан юм. Энэ нь тухайн улс төрийн албан тушаалтан томилох, чөлөөлөхдөө эс үйлдхүйгээр удаашруулах томилж, чөлөөлөхгүй удах эрсдэл бий болгох талтай.

Дээрх эрсдэл бий болсон тохиолдолд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд саад учрах, чанарт сөрөг нөлөөлөл бий болгох бодит нөхцөл байдал бий болгох юм.

Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 заалттай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дахь заалтаар Боловсролын тухай хуулийн "Аймаг, нийслэлийн боловсролын газар" гэсэн 28¹ дүгээр зүйлийн 28¹.1.7 "орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг

сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, шалгаруулалтыг дүнг үндэслэн томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үндэслэн чөлөөлөх” өөрчлөлтөөр оруулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дэх заалтаар Боловсролын тухай хуулийн “Сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх” гэсэн 31 дүгээр зүйлийн 31.1.12.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх” гэх заалтыг хүчингүй болгохоор тусгана.

Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн буюу орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилохтой холбоотой асуудлаар орон нутгийн сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч, түүнчлэн иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсны зэрэгцээ, олон нийтээс санал авах зорилгоор эдгээр хуулийн төслийн хууль санаачлагч өөрийн болон Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсуудад байршуулсан болно

Хуулийн төсөл батлагдаж, хэрэгжсэнээр улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардлагагүй юм.

Хуульч санаачлагч